



УУЛ УУРХАЙ, ХҮНД
ҮЙЛДВЭРИЙН ЯАМАНД

МОНГОЛ УЛСЫН САНГИЙН ЯАМ

15160 Улаанбаатар хот, Чингэлтэй дүүрэг,
С.Данзангийн гудамж 5/1, Засгийн газрын II байр,
Утас/факс: (976-51) 26-74-68, <http://www.mof.gov.mn>

2018.6.25 № 6.1/4100
танай _____-ны № _____-т

Гүйцэтгэгч сонгох ажиллагааг түр хугацаагаар түдгэлзүүлэх тухай

Танай яамнаас зарласан УУХҮЯ/201801001-1 дугаартай “Газрын тосны бүтээгдэхүүний шинжилгээний лабораторийн тоног, төхөөрөмжийг нийлүүлэх” гүйцэтгэгчийг сонгон шалгаруулах тендер шалгаруулалтад оролцсон “Шелтек Монголиа” ХХК-аас Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хууль /цаашид “хууль” гэх/-ийн 55 дугаар зүйлийн 55.1-д заасны дагуу гомдол ирүүлээд байна.


Иймд хуулийн 55 дугаар зүйлийн 55.4-т заасны дагуу дээрх тендер шалгаруулалтын гүйцэтгэгч сонгох ажиллагааг түр хугацаагаар түдгэлзүүлж байна. Гомдлыг хянан шийдвэрлэхэд шаардлагатай дараах баримт бичгүүдийг 2018 оны 6 дугаар сарын 27-ны өдрийн дотор ирүүлнэ үү.

Үүнд:

1. Гэрээ байгуулах эрх олгох тухай захиалагчийн шийдвэр
2. Тендерийн урилга /сонинд зарласан хуулбар/
3. Тендерийн баримт бичиг
4. Тендерт оролцогчдын ирүүлсэн тендер
5. Тендерийн нээлтийн тэмдэглэл
6. Захиалагчийн үнэлгээний хороо зохион байгуулсан шийдвэр
7. Үнэлгээний хорооны гишүүдийн АЗ гэрчилгээний хуулбар
8. Үнэлгээний хорооны хурлын тэмдэглэл, шийдвэр
9. Тендерт оролцогчид болон бусад байгууллагуудтай харилцсан бичиг
10. Гэрээ байгуулах эрх олгох болон шалгараагүй тухай мэдэгдлийг оролцогчид хүргүүлснийг нотлох баримт
11. Гэрээ байгуулах эрх олгосон оролцогчид гомдол гарсан талаар мэдэгдэх
12. Холбогдох бусад баримт бичиг

Гомдлыг хянах явцад тендерийн хүчинтэй байх хугацаа дуусах тохиолдолд хуулийн 29 дүгээр зүйлийн 29.4-т заасан арга хэмжээг авч ажиллана уу.

ТӨРИЙН НАРИЙН
БИЧГИЙН ДАРГА



С.НАРАНЦОГТ



**МОНГОЛ УЛСЫН УУЛ УУРХАЙ,
ХҮНД ҮЙЛДВЭРИЙН ЯАМ**

15160 Улаанбаатар хот, Чингэлтэй дүүрэг,
Нэгдсэн үндэстний гудамж 5/1, Засгийн газрын II байр,
Утас: 26-35-06, Факс: (976-11) 31-81-69,
<http://www.mmhi.gov.mn>

2018.06.28 № 03/1793

танай _____-ны № _____-т

“МЕД ИМПЕКС ИНТЕРНЭШНЛ” ХХК-д

Манай яамнаас зарласан УУХҮЯ/201801001-01 дугаартай “Газрын тосны бүтээгдэхүүний шинжилгээний лабораторийн тоног, төхөөрөмж нийлүүлэгчийг сонгон шалгаруулах /улсын хэмжээнд/ тендер”-ийн гүйцэтгэгч сонгох ажиллагааг тус тендерт оролцогч “Шелтек Монголиа” ХХК-иас гаргасан гомдлын дагуу Сангийн яамнаас 2018 оны 6 дугаар сарын 25-ны өдрийн 6-1/4100 тоот албан бичгээр түр хугацаагаар түдгэлзүүлээд байгааг үүгээр мэдэгдэж байна.

Сангийн яамнаас ирүүлсэн албан бичгийг хавсаргав.

Хавсралт 1. хуудастай.

ТӨРИЙН НАРИЙН БИЧГИЙН
ДАРГА Г.НАНДИНЖАРГАЛ



08 1443



УУЛ УУРХАЙ, ХҮНД
ҮЙЛДВЭРИЙН ЯАМАНД

МОНГОЛ УЛСЫН САНГИЙН ЯАМ

15160 Улаанбаатар хот, Чингэлтэй дүүрэг,
С.Данзангийн гудамж 5/1, Засгийн газрын II байр,
Утас/факс: (976-51) 26-74-68, <http://www.mof.gov.mn>

2019.6.25 № 6.1/4100
танай _____-ны № _____-т

Гүйцэтгэгч сонгох ажиллагааг түр хугацаагаар түдгэлзүүлэх тухай

Танай яамнаас зарласан УУХҮЯ/201801001-1 дугаартай “Газрын тосны бүтээгдэхүүний шинжилгээний лабораторийн тоног, төхөөрөмжийг нийлүүлэх” гүйцэтгэгчийг сонгон шалгаруулах тендер шалгаруулалтад оролцсон “Шелтек Монголиа” ХХК-аас Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хууль /цаашид “хууль” гэх/-ийн 55 дугаар зүйлийн 55.1-д заасны дагуу гомдол ирүүлээд байна.


Иймд хуулийн 55 дугаар зүйлийн 55.4-т заасны дагуу дээрх тендер шалгаруулалтын гүйцэтгэгч сонгох ажиллагааг түр хугацаагаар түдгэлзүүлж байна. Гомдлыг хянан шийдвэрлэхэд шаардлагатай дараах баримт бичгүүдийг 2018 оны 6 дугаар сарын 27-ны өдрийн дотор ирүүлнэ үү.

Үүнд:

1. Гэрээ байгуулах эрх олгох тухай захиалагчийн шийдвэр
2. Тендерийн урилга /сонинд зарласан хуулбар/
3. Тендерийн баримт бичиг
4. Тендерт оролцогчдын ирүүлсэн тендер
5. Тендерийн нээлтийн тэмдэглэл
6. Захиалагчийн үнэлгээний хороо зохион байгуулсан шийдвэр
7. Үнэлгээний хорооны гишүүдийн АЗ гэрчилгээний хуулбар
8. Үнэлгээний хорооны хурлын тэмдэглэл, шийдвэр
9. Тендерт оролцогчид болон бусад байгууллагуудтай харилцсан бичиг
10. Гэрээ байгуулах эрх олгох болон шалгараагүй тухай мэдэгдлийг оролцогчид хүргүүлснийг нотлох баримт
11. Гэрээ байгуулах эрх олгосон оролцогчид гомдол гарсан талаар мэдэгдэх
12. Холбогдох бусад баримт бичиг

Гомдлыг хянах явцад тендерийн хүчинтэй байх хугацаа дуусах тохиолдолд хуулийн 29 дүгээр зүйлийн 29.4-т заасан арга хэмжээг авч ажиллана уу.

ТӨРИЙН НАРИЙН
БИЧГИЙН ДАРГА



С НАРАНЦОГТ

П 537



**МОНГОЛ УЛСЫН УУЛ УУРХАЙ,
ХҮНД ҮЙЛДВЭРИЙН ЯАМ**

15160 Улаанбаатар хот, Чингэлтэй дүүрэг,
Нэгдсэн үндэстний гудамж 5/1, Засгийн газрын II байр,
Утас: 26-35-06, Факс: (976-11) 31-81-69,
<http://www.mmhi.gov.mn>

2018.06.28 № 03/1792
танай 2018.06.25-ны № 6-1/4100 -т

САНГИЙН ЯАМАНД

Танай 2018 оны 06 дугаар сарын 25-ны өдрийн 6-1/4100 тоот гүйцэтгэгч сонгох ажиллагааг түр хугацаагаар түдгэлзүүлэх тухай албан бичгийн дагуу УУХҮЯ/201801001-01 дугаартай “Газрын тосны бүтээгдэхүүний шинжилгээний лабораторийн тоног, төхөөрөмж нийлүүлэгчийг сонгон шалгаруулах /улсын хэмжээнд/ тендер”-ийн холбогдох баримт бичгүүдийг жагсаалтын дагуу бэлтгэн үүгээр хүргүүлж байна.

Хавсралт ... хуудастай.

ТӨРИЙН НАРИЙН БИЧИЙН
ДАРГА Г.НАНДИНЖАРГАЛ



08 1447



УУЛ УУРХАЙ, ХҮНД ҮЙЛДВЭРИЙН
ЯАМАНД

МОНГОЛ УЛСЫН САНГИЙН ЯАМ

15160 Улаанбаатар хот, Чингэлтэй дүүрэг,
С.Данзангийн гудамж 5/1, Засгийн газрын II байр,
Утас/факс: (976-51) 26-74-68, <http://www.mof.gov.mn>

2018.07.05 № 6-1/4484
танай _____-ны № _____-т

Гомдлын хариу

Танай байгууллагаас зарласан УУХҮЯ/201801001-1 дугаар бүхий “Газрын тосны бүтээгдэхүүний шинжилгээний лабораторийн тоног төхөөрөмж нийлүүлэх” гүйцэтгэгчийг сонгон шалгаруулах тендер шалгаруулалтад оролцсон “Шелтек Монголиа” ХХК-аас гаргасан гомдлыг Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 55.2-т заасны дагуу холбогдох баримт материалд үндэслэн хянан үзлээ. Үүнд:

“Шелтек Монголиа” ХХК-ийн ирүүлсэн тендер захиалагчийн боловсруулсан тендерийн баримт бичигт заасан ямар шалгуур үзүүлэлтийг хангаагүй талаар мэдэгдэлд тодорхой дурдаагүй байгаа нь хуулийн 29 дүгээр зүйлийн 29.1-д “Захиалагч ... тендер ирүүлсэн оролцогчид гэрээ байгуулах эрх олгохоор шийдвэрлэж, энэ тухай түүнд болон бусад тендерт оролцогч бүрд шалгараагүй үндэслэлийн хамт нэгэн зэрэг бичгээр мэдэгдэнэ” гэж заасныг зөрчсөн байна.


Цахим санхүүгийн тайлан /e-balance.gov.mn/-аас “Шелтек Монголиа” ХХК-ийн борлуулалтын орлогыг хянан үзэхэд 2016 онд 3.6 сая, 2017 онд 107.9 сая төгрөг тус тус байгаа нь захиалагчийн боловсруулсан тендерийн баримт бичгийн тендерт оролцогчдод өгөх зааварчилгааны тендер шалгаруулалтын өгөгдлийн хүснэгтийн 18.2-ын (а)-д 2016, 2017 оны аль нэг жилийн борлуулалтын орлогын хэмжээ нь тендерт санал болгож буй үнийн дүнгээс багагүй байх (оролцогчийн тендерт ирүүлсэн үнийн санал 1188.5 сая төгрөг байна) гэж заасан шалгуур үзүүлэлтийг хангаагүй, мөн түншлэгч “Шелтек Аг” ХХК-ийн талаар холбогдох мэдээллийг тендерт ирүүлээгүй байх тул хуулийн 27 дугаар зүйлийн 27.4 дэх хэсэгт заасны дагуу уг тендерээс татгалзсан захиалагчийн үндэслэлтэй байна.

Иймд дээрх тендер шалгаруулалтын үйл ажиллагааг цааш үргэлжлүүлэхийг үүгээр мэдэгдье.

Цаашид худалдан авах ажиллагааг зохион байгуулахдаа хуулийн 46 дугаар зүйлийн 46.1-д заасны дагуу захиалагчийн эрх, үүргийг хэрэгжүүлж ажиллахыг анхааруулж байна.

Хувийг: “Шелтек Монголиа” ХХК-д.

ТӨРИЙН НАРИЙН
БИЧГИЙН ДАРГА



С.НАРАНЦОГТ

6 637



УУЛ УУРХАЙ, ХҮНД
ҮЙЛДВЭРИЙН ЯАМАНД

МОНГОЛ УЛСЫН САНГИЙН ЯАМ

15160 Улаанбаатар хот, Чингэлтэй дүүрэг,
С.Данзангийн гудамж 5/1, Засгийн газрын II байр,
Утас/факс: (976-51) 26-74-68, <http://www.mof.gov.mn>

2018.7.9. № 6-1/4525
танай _____-ны № _____-т

Хугацаа сунгах тухай

Танай байгууллагаас зарласан УУХҮЯ/201801001-1 дугаар бүхий “Газрын тосны бүтээгдэхүүний шинжилгээний лабораторийн тоног төхөөрөмж нийлүүлэх” гүйцэтгэгчийг сонгон шалгаруулах тендерийн хүчинтэй байх хугацааг сунгуулах зөвшөөрөл хүссэн албан бичигтэй танилцлаа.

Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.4, 29.5-д заасны дагуу дээрх тендерийн хүчинтэй байх хугацааг 30 хоногоор сунгаж байна.

Тус хугацаа нь тендерийн хүчинтэй байх хугацаа дууссан өдрөөс тоологдох болохыг анхаарна уу.

ТӨРИЙН НАРИЙН
БИЧГИЙН ДАРГА



С.НАРАНЦОГТ